



**ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 04 сарын 24 өдөр

Дугаар А/218

Эрдэнэт

Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6/а/, 29. 2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг.Монгол-Оросын Найрамдал, хамтын ажиллагааны 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд Эх орны дайны ялалтын 72 жилийн ойд бэлтгэх, тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээг батлагдсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулж явуулахыг Цэргийн штаб /Хурандаа н.Батсуурьт/-т даалгасугай.

Хоёр.Эх орны дайны ялалтын 72 жилийн ойн арга хэмжээнд шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.

Гурав.Эх орны дайны ялалтын 72 жилийн ойн арга хэмжээнд шаардагдах зардал 3000000 /Гурван сая / төгрөгийг Засаг даргын нөөц зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэгт/-т зөвшөөрсүгэй

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ

Аймгийн Засаг даргын 2017 оны 1 сарын 2-ны  
 өдрийн 88 дугаар захирамжийн хавсралт

**ЭХ ОРНЫ ДАЙНЫ ЯЛАЛТЫН 72 ЖИЛИЙН ОЙН ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭГ  
 ЗОХИОН БАЙГУУЛЖ ЯВУУЛАХАД ШААРДАГДАХ ЗАРДАЛ**

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээнүүд  | Хугацаа    | Нэгж/тегереер/<br>Бүгд тегрөг   | Тайлбар        |
|---|--|------------|---|----------------|
| 1 | 1945 оны Чөлөөлөх дайнд оролцсон ахмад дайчдад дэмжлэг үзүүлэх   | V/09       | Ахмад дайчин 6 x 150000 төгрөг = 900000<br>Хадаг 6 ширхэг x 2500 = 15000  | 915000         |
| 2 | Эх орны дайны ялалтын 72 жилийн ойд зориулсан "Агуу их ялалт" сэдэвт гар зургийн уралдаан зохион байгуулах зардал                                | V/1-8      | "Агуу их ялалт" сэдэвт гар зургийн уралдаан 9 байр x 25000 = 225000   | 225000         |
| 3 | Эх орны дайны ялалтын 72 жилийн ойд зориулсан эх орны дайны тухай шилдэг зохион бичлэг, дуу, шүлэг болон бүжгийн тэмцээн зохион байгуулах зардал | V/1-8      | Эх орны дайны тухай дуу 9 байр x 40000 = 360000<br>Эх орны дайны тухай шүлэг 3 байр x 40000 = 120000<br>Эх орны дайны тухай бүжиг 6 байр x 40000 = 240000       | 720000         |
| 4 | Эх орны дайны ялалтын 72 жилийн ойд зориулсан Хүүхдийн жагсаалын болон баярын маршийг зохион байгуулах зардал                                    | V/1-8      | Тэргүүний жагсаалч тасаг 5 байр x 50000 = 250000<br>Тэргүүний тасгийн захирагч 5 байр x 25000 = 125000  | 375000         |
| 5 | Эх орны дайны ялалтын 72 жилийн ойд зориулсан хэвлэл мэдээлэл, ахмад дайчдын зураг хэвлүүлэх зардал  | V/1-10     | Эх орны дайны ялалтын 72 жилийн ойд зориулсан "Мөхөшгүй хороо" жагсаалтад орох дайнд оролцсон ахмад дайчдын фото зураг, жааз хийлгэх 10 ширхэг x 15000 = 150000 | 150000         |
| 6 | Эх орны дайны ялалтын 72 жилийн ойд зориулсан хэвлэл мэдээллийн зардал   | IV/25-V/10 | Сонин материал хэвлүүлэх зардал   | 205000         |
| 7 | 2017 оны 05 дугаар сарын 09-нд Амарын талбайд болох арга хэмжээнд  |            | Цэрэг эх орны сэдэвт соёл урлагийн арга хэмжээнүүд  | 410000         |
| 8 | <b>Бүгд</b>  |            |   | <b>3000000</b> |